

**Эрдмийн зөвлөлийн 2012 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн
хурлаар хэлэлцэн батлав.**

**ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ ИХ СУРГУУЛИЙН
ЗАЙНЫ СУРГАЛТЫН ЖУРАМ**

Нэг. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

1.1 Монгол Улсын Их Хурлын 2002 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль, 2000 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын мэдээлэл, харилцаа, холбооны технологийн хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт зайн сургалтын талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улсын Засгийн Газрын 2002 оны 01 сарын 25-ны өдрийн Зайны сургалтын үндэсний хөтөлбөр батлах тухай 14 тоот тогтоол, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль (цаашид ХИС гэх)-ийн дүрэм, Стратеги төлөвлөгөөг тус тус үндэслэн, зайны сургалт явуулахад энэхүү журмыг баримтална.

1.2 ХИС-ийн Зайны сургалтын үндсэн зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан дээд боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн суралцагчдад алслагдсан зайнаас БШУЯ-наас баталсан мэргэжлийн дээд боловсролын мэдлэг олгоход оршино.

1.3 Зайны сургалт гэж компьютерийн болон харилцаа холбооны бусад арга, хэрэгслийн тусламжтайгаар сургалтын төвөөс алслагдсан оюутнуудад сургалт-танин мэдэхүйн үйл ажиллагааг тодорхой чиглэлээр, нэгдмэл арга зүй, зохион байгуулалттайгаар удирдах явцыг хэлнэ.

Хоёр. ЗАЙНЫ СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2.1 Зайны сургалтын технологиор боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь ХИС болон түүний салбар сургуулиуд, Зайны сургалтын төв дээр зохион байгуулагдана.

2.2 ХИС-д зайны сургалтын технологиор суралцагчдын эрх үүрэг нь ХИС-ийн бүх шатны сургалтанд хамрагдагчидтай адил тэгш байна.

Гурав. ЗАЙНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

3.1 Зайны сургалтад хамрах мэргэжлийн дээд боловсролын сургалтын хөтөлбөрүүд нь тухайн мэргэжилтэнг уламжлалт аргаар бэлтгэх боловсролын агуулгыг баримталж, түүнийг бүрэн хэмжээгээр олгоход чиглэсэн байна.

3.2 Зайны сургалтын технологи ашиглан бэлтгэх мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүд нь сургалтын технологийн шинэчлэлд тулгуурласан, сурах ба сургах, үнэлэх үйл ажиллагааг зохион байгуулах төрөл бүрийн арга хэлбэрийг ашиглах боломжтой байна.

3.3 ХИС-д суралцагчдын хувьд заавал үзэх хичээлийн агуулга болон зайн сургалтын хугацаа нь элсэгчдийн дипломын боловсролын түвшингээс хамааран бүх шатны сургалтанд адил байна

3.4 Ганцаарчилсан болон богиносгосон хугацаагаар боловсролын хөтөлбөрийг бүрэн эзэмшүүлэх үйл ажиллагааг ХИС-иас баталсан ганцаарчилсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж болно.

Дөрөв. ХИС-ийн ЗАЙНЫ СУРГАЛТАД ЭЛСҮҮЛЭХ

4.1 ХИС-д оюутан элсүүлэх зохих журмын дагуу зайны сургалтаар дээд боловсрол эзэмшүүлэх элсэлтийг зохион байгуулна.

4.2 Зайны сургалтанд элсэн орсон оюутанд сургалтанд ашиглах Веб хуудас болон сургалтын бусад мэдээллийн сан руу нэвтрэх хэрэглэгчийн эрхийг олгоно.

4.3 Зайны сургалтанд элсэн суралцахаар хүсэлт гаргагчийг энэ сургалтанд хамрагдахад тавигдах техникийн шаардлагыг (утас, интернет, шуудан г.м.) бүрэн хангасан тохиолдолд бүртгэнэ.

Тав. ЗАЙНЫ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

5.1 Зайны сургалтын төлөвлөгөө нь Боловсрол Шинжлэх Ухааны Яамнаас баталсан ХИС-ийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын төлөвлөгөө байна.

5.2 Сургалтын төлөвлөгөөний үндсэн дээр сургалтын нэгдсэн хуанли гаргасан байна. Сургалтын үйл ажиллагааны явцад гүйцэтгэх даалгавар, хяналтын ажилд зориулсан цаг болон шалгалтын хугацааг тодорхой зааж өгнө.

5.3 Зайны сургалтад лекц, зөвлөгөө, семинар, дадлагын хичээл, лабораторийн ажил, хяналтын ажил, бие даалтын ажил, эрдэм шинжилгээний ажил, дадлага, курсийн ажил, дипломын ажил зэрэг сургалтын үндсэн хэлбэрүүдийг ашиглана. ХИС-иас зайны сургалтын бусад хэлбэрийг тогтоож болно.

5.4 Сургалтын хэлбэрүүдийг хэрэгжүүлэхэд е-сургалтын материалууд болон зайн сургалтын технологийг хэрэглэнэ.

ХИС-ийн зайны сургалтын үйл ажиллагаа нь:

- Багш, анги танхимд эсвэл компьютерийн болон мэдээлэл, харилцаа холбооны техник, хэрэгслийн тусламжтайгаар оюутантай харилцах
- Оюутан сургалтын материалтай бие даан ажиллах гэсэн хэлбэрээр явагдана.

5.5 Хоёр дахь дээд боловсрол, эсвэл мэргэжлийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрт хамрагдсан тохиолдолд хичээлийн жилийн эхлэх хугацаа нь оюутан элсүүлсэн тухай захирлын тушаалаар батлагдана.

Зургаа. ОЮУТНЫ МЭДЛЭГИЙГ ҮНЭЛЭХ, ДҮГНЭХ

6.1 ХИС-ийн “Оюутны мэдлэг, чадварыг үнэлэх журам”-ын дагуу оюутны мэдлэгийг үнэлж, дүгнэнэ.

6.2 Төгсөлтийн дипломын ажил бичиж буй оюутан нь заавал өөрийн биеэр хүрэлцэн ирж төгсөлтийн дипломын ажлаа хамгаална.

Долоо. ЗАЙНЫ СУРГАЛТЫН МЭДЭЭЛЭЛ, ПРОГРАМ, ТЕХНИК ХАНГАМЖ

7.1 Сургалтын явцыг удирдах болон сургалтын материалыг суралцагчдад хүртээхийн тулд зайны сургалтын систем болон түүнд суурилсан цахим мэдээллийн санг ашиглана.

7.2 Цахим мэдээллийн сан нь электрон номын сан, электрон хичээлийн сан, тестийн сан г.м. эх үүсвэрээс бүрдэх ба эдгээр нь сургалтын үйл явцыг хэрэгжүүлэх болон суралцагчдад чанартай мэдлэг олж авах боломжийг бүрэн хангасан, нээлттэй хэлбэртэй байна.

7.3 Электрон хичээлийн санг бүрдүүлэхдээ ХИС-ийн хэмжээнд мөрдөх е-сургалтын хичээл боловсруулах стандартийн дагуу багшийн боловсруулсан материалыг ХИС-ийн Зайны сургалтын төвд түшиглэн байгуулагдсан е-сургалтын комисс шүүн хэлэлцэж хүлээн авна.

7.4 Зайны сургалтын төв түшиглэн ажиллах е-сургалтын комиссыг ХИС-ийн захирлын тушаалаар байгуулна.

7.5 Зайны сургалтын програм-техник, сүлжээний хэрэгсэл нь сургалтын төлөвлөгөөний дагуу мэргэжил олгох үйл ажиллагааг зохион байгуулахад хангалттай хүрэлцэхүйц байна.

7.6 Харилцаа холбооны болон серверийн тоног төхөөрөмжүүд, хувилах техник, сканнер зэргийг хяналт, хамгаалалтын шаардлага хангасан тусгай өрөө тасалгаанд байршуулна.

Найм. ХИС-ийн ЗАЙНЫ СУРГАЛТЫН БОЛОВСОН ХУЧИНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

8.1 ХИС нь багш-профессорын нийт бүрэлдэхүүн, инженер-техникийн болон сургалтын туслах ажилтнуудыг давтан сургалтад хамруулж, үндэсний болон олон улсын сертификат бүхий зэрэглэл олгуулах ба тэдний ажиллах нөхцөлийг мэдээллийн болон боловсролын технологийн зохих шаардлагын түвшинд байнга хангаж, аттестатчилж байна.

8.2 ХИС-ийн Зайны сургалтын төв нь компьютерийн сүлжээ болон мэдээллийн санг удирдах дадлага, чадвар, мэдлэг мэргэшил эзэмшсэн мэргэжилтнүүдтэй байна.

Ес. ХИС-ийн ЗАЙНЫ СУРГАЛТ ДАХЬ АКАДЕМИК ЭРХ

9.1 ХИС нь сургалтын процессын технологийн түвшинтэй уялдуулан боловсролын хөтөлбөр, курс болон хичээлийн хөтөлбөр, сургалтын болон үйлдвэр-сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах эрхтэй.

9.2 Багш-профессорын бүрэлдэхүүн нь тухайн курсын хичээлийн агуулга, сургалтын процессыг илүү чанартай болгоно гэж үзсэн зайн сургалтын заах арга, хэрэгсэл, технологи сонгох, төрөөс мөрдүүлж байгаа боловсролын стандартад нийцүүлэн курс сургалтын агуулга, хэмжээ, хичээлийн төрлийг тогтоох эрхтэй.

Арав. БУСАД ЗҮЙЛ

10.1 Суралцагчдын шилжилт хөдөлгөөн нь ХИС-ийн “Оюутны мэдлэг, чадварыг үнэлэх журам”-ийн 19-р зүйлийн дагуу явагдана.

10.2 Зайн сургалтаар хичээл заах багш нарын нэрсийг ХИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулах ба багшийн сургалтын ажлын гүйцэтгэл, явцад сургалт, судалгааныхөгжил, аудитынүнэлгээнийалба, Эрдмийн сургуулийн сургалтын алба хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллана.

10.3 Зайн сургалтын төлбөрийн хэмжээ, нэг кредитийн үнэлгээг тухайн хичээлийн жилийн 6 сарын эхний 15 хоногт багтаан тооцоолж, ХИС-ийн Удирдах зөвлөлөөр батлуулна.